



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/297

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.6, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.4, 19.1.5, 19.1.6, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/80, А/132, А/60 дугаар хамтарсан тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит бус XIII хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчлэх “Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа”-ны зардалд 40,000,000 (дөчин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Уг зардлыг Засаг дарга дансны “Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр”-өөс гаргаж зарцуулахыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий санхүүчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр), үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Ганбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН